



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/591

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Ханжаргалант худалдааны төвөөс Хаан банк хүртэл явган зам шинээр барих (Булган сум) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Өвөлжөөн булаг” ХХК-тай 142 541 376 (нэг зуун дөчин хоёр сая таван зуун дөчин нэгэн мянга гурван зуун далан зургаа) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.


2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Өвөлжөөн булаг” ХХК-ийн захирал (Б.Өлзийбаяр)-д даалгасугай.

4.Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010630

Аймгийн Засаг даргын 2023 оны
08 дугаар сарын 11-ны өдрийн
А/591 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	2,527,237	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	2,527,237	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	1,263,618	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	4,500,000	Ү.Бямбасүрэн
5	Нормчлолын сан	227,451	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.1 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
7	Ажил гүйцэтгэх хугацаа	42 хоног	Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь байна.	Д.Батцогт